



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



2026 VIII

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 8 дугаар сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2024-2026 он	1
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	2
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20
IX	Аж үйлдвэр	24
X	Хөдөмөр	27

ХҮСНЭГТ 1. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 VIII	2025 VIII	2026 VIII
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	1289 ^{↓17.1}	1316 ^{↑2.1}	1141 ^{↓13.3}
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	824 ^{↓15.2}	1771 ^{↑114.9}	1185 ^{↓33.1}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	1.2 ^{↑1.0}	2.1 ^{↓0.9}	1.1 ^{↓1.0}
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	142.5 ^{↑18.8}	177.5 ^{↑24.6}	206.5 ^{↑16.3}
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	140.8 ^{↑32.5}	177.2 ^{↑25.9}	176.5 ^{↓0.4}
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ = ₮	3 399.0 ^{↓1.6}	3 592.9 ^{↑5.7}	3 595.6 ^{↑0.08}

ХҮСНЭГТ 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо ¹	Хүн ам зүйн ачаалал ²
	36 782	129 116	3.5	56.1
1 -р хороо	847	3 197	3.8	65.4
2 -р хороо	962	3 177	3.3	64.1
3 -р хороо	1 541	5 405	3.8	62.4
4 -р хороо	1 237	4 874	3.9	57.4
5 -р хороо	1 180	4 441	3.8	58.0
6 -р хороо	2 489	9 084	3.6	63.6
7 -р хороо	1 807	5 984	3.3	52.2
8 -р хороо	863	2 998	3.5	49.8
9 -р хороо	1 489	5 267	3.5	51.0
10 -р хороо	1 981	7 325	3.7	56.9
11 -р хороо	1 176	4 189	3.6	51.2
12 -р хороо	1 529	5 372	3.5	53.4
13 -р хороо	1 743	6 397	3.7	57.1
14 -р хороо	1 559	5 150	3.3	53.5
15 -р хороо	2 060	7 358	3.6	54.6
16 -р хороо	2 030	7 393	3.6	58.0
17 -р хороо	2 161	7 059	3.3	53.9
18 -р хороо	1 570	5 758	3.7	49.2
19 -р хороо	2 061	6 857	3.3	52.3
20-р хороо	1 274	4 268	3.4	53.4
21-р хороо	1 893	6 993	3.7	57.5
22-р хороо	1 184	4 035	3.4	56.0
23 -р хороо	1 218	3 945	3.2	59.5
24 -р хороо	928	2 590	3.8	60.5

¹ Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

² Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрум	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

2026 оны эхний 8 сард 1141 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 175 (13.3%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2026 оны эхний 8 сард 1141 эх амаржиж, 1151 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс


төрсөн эх 175 (13.3%) мэндэлсэн хүүхэд 172 (13.0%) -ээр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ЭХ, ХҮҮХЭД, ЭНДЭГДЭЛ, 2026 оны эхний 8 сард

Үзүүлэлт	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII	Өсөлт, бууралт 2025-2026	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	1 274	1 316	1 141	-175	-13.3
Амьд төрсөн хүүхэд	1 289	1 323	1 151	-172	-13.0
Нас барсан хүн	562	560	512	-48	-8.6
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	14	15	14	-1	-6.7
1-5 настай хүүхдийн эндэгдэл	5	3	1	-2	-66.7
Амьгүй төрөлт	11	7	5	-2	-28.6
Гэрийн төрөлт	6	5	3	-2	-40.0
Хяналтгүй төрөлт	14	8	9	1	12.5

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл


ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар



2026 оны эхний 8 сард нийт 598299 удаа эмчийн үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55710 (10.3%), эмнэлэгт

хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 4404 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 594 (15.6%) хүнээр тус тус өсжээ.

ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Бэлгийн замын халдварт өвчин 134 буюу нийт халдварт өвчний 11.3 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, 2026 оны эхний 8 сарын байдлаар

Төрөл	2024 I-VIII		2025 I-VIII		2026 I-VIII		2026/2025	
	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	824	59.0	1856	137.8	1185	90.4	-671	-36.2
Гепатит	5	0.4	9	0.7	6	0.5	-3	-33.3
Цусан суулга	85	6.1	45	3.3	41	3.1	-4	-8.9
Сальмонеллез	26	1.9	17	1.3	10	0.8	-7	-41.2
Хоолны хордлого	32	2.3	18	1.3	17	1.3	-1	-5.6
Менингококкт	0	0.0	3	0.2	0.0	0.0	-3	-
Салхин цэцэг	259	18.5	381	28.3	213	16.2	-168	-44.1
Гахайн хавдар	15	1.1	3	0.2	6	0.5	3	2*
Улаан эсэргэнэ	22	1.6	38	2.8	32	2.4	-6	-15.8
Ёлом	6	0.4	8	0.6	9	0.7	1	12.5
Бруцеллёз	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Гар, хөл, ам	77	5.5	43	3.2	410	31.3	367	-
В34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй	0	0.0	85	6.3	57	4.3	-28	-32.9
Хачигт риккетсиоз	1	0.1	0	0.0	0	0.0	0	-
Эритема	0	0.0	117	8.7	26	2.0	-91	-77.8
Ковид-19	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Улаан бурхан	0	0.0	712	52.9	101	7.7	-611	-85.8
Халдварын гаралтай суулга	0	0.0	4	0.3	0	0.0	-4	-
Бусад	0	0.0	83	6.2	45	3.4	-38	-45.8
Тэмбүү	94	6.7	88	6.5	60	4.6	-28	-31.8
Төрөлхийн тэмбүү	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Заг хүйтэн	32	2.3	39	2.9	14	1.1	-25	-64.1
Сүрьеэ	86	6.1	91	6.8	78	6.0	-13	-14.3
Мөөгөнцөр	15	1.1	16	1.2	13	1.0	-3	-18.8
Трихомониаз	69	4.9	56	4.2	47	3.6	-9	-16.1
ХДХВ/ДОХ	0	0.0	0	0.0	0	0	0	-

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн

хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

I-XII/2025


Тархаасан: 2025 оны 09 дүгээр сарын 15

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 8 сард 530.3 тэрбум төгрөгт хүрлээ.


ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг

Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 42.8 (11.1%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 4.8 (11.6%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-

ний даатгалын сангийн орлого 5.1 (16.3%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 1.9 (12.0%) тэрбум төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг



Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 21.7 (12.3%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3.0 (29.5%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 2.5

(44.5%) тэрбум төгрөгөөр өссөн бол YOMSHO-ний даатгалын сангийн зарлага 0.2 (19.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 8 дугаар сарын байдлаар 98.8 мянган хүнд 71.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад

хамрагдсан хүн 920 (0.9%) буурч, олгосон тэтгэмж 2.2 (3.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	Нийгмийн халамжийн үйлчилгээ		Өөрчлөлт	
	2025 I-VIII	2026 I-VIII	Тоо	Хувь
	сая төгрөг	сая төгрөг		
Нийт	69 262.0	71 429.0	2 167.	3.1
Нийгмийн халамжийн тэтгэвэрт	7 659.8	9 049.0	1 389.2	18.1
Нийгмийн халамжийн тэтгэмж	49 338.6	48 697.2	- 641.4	-1.3
Асаргааны тэтгэмж	6 794.3	7 800.2	1 005.9	14.8
Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох	2 634.3	2 907.2	272.9	10.4
Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж	287.8	632.9	345.1	119.9
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	2 547.3	2 342.5	- 204.8	-8.0

Үүнээс, нийгмийн халамжийн тэтгэмжэнд 2026 оны эхний 8 дугаар сарын байдлаар 69679 хүн хамрагдаж 48.7 тэрбум төгрөг

олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 1028 (1.5%) буурч, олгосон мөнгөн тэтгэвэр 0.6 (1.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ

I-XII/2026


Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 2482 гэмт хэрэг бүртгэгдсэн өнгөрсөн жилийн мөн үеэс 13.0 хувиар буурсан байна.

2026 оны эхний 8 сард 2482 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 370 (13.0%) хэргээр буурсан үзүүлэлтэй байна. Гэмт хэргийн улмаас 56.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс

23.7 тэрбум төгрөгөөр буюу 73.1 хувиар өссөн байна. Харин уг хохирлоос 15.6 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн нь нийт хохирлын 27.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 38.0 хувийг залилан, 18.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 17.7 хувийг хулгайн, 1.2 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 2.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын

журмын эсрэг, 1.0 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.2 хувийг дээрэм, 0.3 хувийг хүчин, 16.4 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, эхний 8 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII	Тоо	Хувь
Дүүргийн дүн	1 957	2 852	2 482	-370	-13.0
Хүний амь	2	3	2	-1	-33.3
Хүчин	9	13	8	-5	-38.5
Дээрэм	29	42	55	13	31.0
Хулгай	396	384	440	56	14.6
Залилан	700	1 327	943	-384	-28.9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	416	401	453	52	13.0
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	86	123	120	-3	-2.4
Бусдыг амиа хорлоход хүргэх	7	34	24	-10	-29.4
Бусдын хөрөнгө ашиглах	21	29	30	1	3.4
Бусад гэмт хэрэг	291	496	407	-89	-17.9

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	19 586	23 591	23 853	262	1.1
Багануур	202	274	265	-9	-3.3
Багахангай	16	16	19	3	18.8
Баянгол	3 392	4 029	4 637	608	15.1
Баянзүрх	5 496	5 499	5 973	474	8.6
Налайх	246	232	363	131	56.5
Сонгинохайрхан	2 536	3 065	3 340	275	9.0
Сүхбаатар	2 715	3 530	3 504	-26	-0.7
Хан-Уул	3 026	4 094	3 270	-824	-20.1
Чингэлтэй	1 957	2 852	2 482	-370	-13.0

2026 оны эхний 8 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурсан боловч хулгай, дээрэм болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өссөн байна. Ялангуяа дээрмийн гэмт хэрэг 31.0 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй үзүүлэлт байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд

16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох

бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл

мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-XII/2026


Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Дүүргийн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өслөө.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 8 сарын байдлаар 206.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 27.1 (11.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 97.2 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.8 хувийг татварын бус

орлого эзэлж байна. 2026 оны эхний 8 сарын байдлаар дүүргийн татварын орлого 199.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 22.0 (12.5%) тэрбум төгрөгөөр, дутуу, татварын бус орлого 5.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.5 (34.7%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ЗУРАГ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 8 сарын байдлаар


Үзүүлэлт	Төлөвлөгөө (сая төгрөг)	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	233 674.7	206 535.5	-27 139.3	-11.6
А. Урсгал орлого	232 763.8	205 639.2	-27 124.6	-11.7
1. Татварын орлого	228 524.4	199 948.3	-28 576.1	-12.5
1.1. Орлогын албан татвар	202 330.4	180 315.7	-22 014.7	-10.9
1.2. Өмчийн татвар	4 350.8	3 928.1	- 422.7	-9.7
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	21 843.2	15 704.5	-6 138.6	-28.1
2. Татварын бус орлого	4 239.4	5 690.9	1 451.5	34.2
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	911.0	896.3	- 14.7	-1.6

*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

2026 оны эхний 8 сарын байдлаар төсөвт нийт 206.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. Энэ нь төлөвлөсөн орлогоос 27.1 тэрбум төгрөгөөр буюу 11.6 хувиар бага байна. Орлогын дийлэнх хэсгийг татварын орлого

бүрдүүлдэг бөгөөд 199.9 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 28.6 тэрбум төгрөгөөр бага байна. Харин татварын бус орлого 5.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 34.2 хувиар давсан байна.


ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО



ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 8 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	сая төгрөг			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	252 758.9	203 530.8	-49 228.1	-19.5
А. Урсгал зарлага	220 902.9	176 468.7	-44 434.3	-20.1
1. Бараа, үйлчилгээний зардал	73 709.5	50 814.1	-22 895.5	-31.1
1.1. Цалин, хөлс	5 656.7	5 213.0	- 443.7	-7.8
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 846.6	1 379.7	- 466.9	-25.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	66 206.2	44 221.4	-21 984.9	-33.2
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	147 193.4	125 654.6	-21 538.8	-14.6
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	147 193.4	125 654.6	-21 538.8	-14.6
Б. Хөрөнгийн зардал	31 855.9	27 062.2	-4 793.8	-15.0
Хөрөнгө оруулалт	31 855.9	27 062.2	-4 793.8	-15.0

ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Нийслэлийн хэмжээнд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 12.5 хувь, өмнөх сараас 1.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар




Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2026 оны 8 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 10.2 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 18.4 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 10.5 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 5.6 хувь, эм тариа,

эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 5.0 хувь, тээвэр 10.8 хувь, боловсролын үйлчилгээ 17.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 14.3 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ 17.1 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2026 VIII 2025 VIII	2026 VIII 2025 XII	2026 VIII 2026 VII
Ерөнхий индекс	12.5	10.2	1.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	21.5	18.4	-2.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	14.2	10.5	2.0
Хувцас, бөс бараа, гутал	7.4	3.3	0.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.4	4.4	1.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	8.9	5.6	0.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.1	5.0	0.9
Тээвэр	11.2	10.8	2.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.6	0.9	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	7.7	5.0	2.6
Боловсролын үйлчилгээ	17.4	17.4	17.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	16.4	14.3	1.1
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	17.1	17.1	0.1
Бусад бараа, үйлчилгээ	9.4	4.9	0.7


ЗУРАГ 11. ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 сард, төгрөг




ЗУРАГ 12. ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 сард, төгрөг



ЗУРАГ 13. ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 сард, төгрөг



ЗУРАГ 14. ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, ЖИЛ БҮРИЙН 8 САРД, ТӨГРӨГ



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
 P_{it}^i – i барааны тайлант үеийн үнэ
 P_{i0}^i – i барааны тайлант үеийн үнэ
 Q_{i0}^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла



НИЙТИЙН АЖ АХУЙ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 22372.5 тн хог тээвэрлэжээ.

ХҮСНЭГТ 11. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2026 оны 8 дугаар сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 VIII	2025 VIII	2026 VIII	2025/2026	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м ²	2 908.5	2 908.5	2 908.5	-	-
Тээвэрлэсэн хог	Тн	26 369.6	31 044.3	22 372.5	-8 671.8	-27.9
Орон сууц	Тн	-	-	4 928.7	4 928.7	-
Гэр хороолол	тн	22 232.4	21 413.8	16 861.4	-4 552.4	-21.3
Албан газар	тн	4 137.2	9 630.5	582.4	-9 048.1	-94.0
Зам талбай	Тн	0.0	0.0	0.0	-	-
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	2 376.3	2 594.9	2 370.2	-224.7	-8.7
Зам талбай	сая.төг	1 142.2	1 142.2	1 323.2	181.0	15.8
Гэр хороолол	сая.төг	1 040.5	1 002.1	786.1	-216.0	-21.6
Орон сууц	сая.төг	148.2	408.5	230.7	-177.8	43.5
Албан газар	сая.төг	45.4	42.1	30.3	-11.9	-28.2

*Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК

Тээвэрлэсэн хог 2026 оны 08 дугаар сард 22372.5 болж, өмнөх жилийн мөн үеэс 8671.8 тн (27.9%) буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 2370.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 224.7 (8.7%) сая төгрөгөөр өсчээ.

Орлогын эх үүсвэрийг ангилбал 33.2 хувийг гэр хороолол, 55.8 хувийг зам талбай, 9.7 хувийг орон сууц, 1.3 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 30323 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17644 (36.8%) зөрчилөөр буурсан байна.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2026 оны эхний 8 дугаар сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 30323 зөрчил илрүүлсэн. Сogтуугаар тээврийн хэрэгсэл

жолоодсон 738 холбогдогчийг шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийлгэснээс 738 иргэнийг 1 жил тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 735 хүнд торгож, баривчлах шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 12.

ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII
Торгуулсан хүний тоо	52 256	47 967	27 339
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	812.5	1475.1	696.3

ХҮСНЭГТ 13.

ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII
НИЙТ ЗӨРЧИЛ	52 253	47 967	30 323
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	1 042	852	738
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	481	896	908
Бүрэн бүс тээврийн хэрэгсэл жолоодсон	3 444	4 972	3 712
Хамгаалах бүс хэрэглээгүй	8 604	7 011	4 025
Хориглосон нөхцөлөөр зогссон	8 368	2 941	276
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	27	21	54
Эгнээ байраа буруу эзэлсэн	1 266	1 351	1 499
Бусад зөрчил	29 021	29 923	17 848

*Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 114 буюу 13.4 хувиар буурсан бол тээврийн

хэрэгсэл жолоодох эрхгүй боловч жолоодсон зөрчил 12 буюу 1.3 хувиар өссөн байна. Мөн эгнээ байраа буруу эзэлсэн зөрчил 148 буюу 10.9 хувиар өссөн байна.



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

2026 оны эхний 8 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 53686 удаа үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1394 (2.6%) өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

Үзүүлэлт	2025 I-VIII	2026 I-VIII	2025/2026	
	Дүнгээр		Дүн	Хувь
Нийт	52 292	53 686	1 394	2.6
Шинэ төрсөн	1 608	1 530	- 78	4.9
Гэрлэлт	396	405	9	2.2
Гэр бүл цуцлалт	215	207	- 8	3.7
Хүүхэд үрчлэлт	32	22	- 10	31.3
Эцэг тогтоосон	77	46	- 31	40.3
Овог, нэр өөрчлөх	76	86	10	13.1
Шилжин ирсэн	3 734	3 801	67	1.7
Лавлагаа	36 439	39 070	2 631	7.2
Иргэний үнэмлэх олголт:	9 715	8 519	- 1 196	12.3
16 нас хүрч шинээр авсан	2 385	2 295	- 90	3.8
Дахин олголт	7 330	6 224	- 1 106	15.1

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Онцгой байдал:

Аюулт үзэгдэл, ослын дуудлага 2026 оны эхний 8 сард 336 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 66 (16.4%)-аар буурсан байна. Тохиолдсон аюулт үзэгдэл, ахуйн 240 гал түймэр гарч,

өмнөх оны мөн үеэс 78(24.5%)-аар буурсан бөгөөд гал түймрийн аюулаас 810 хүн, 152.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

ХҮСНЭГТ 15. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлтүүд	2024 I-VIII	2025 I-VIII	2026 I-VIII	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	256	402	336	-66	-16.4
Худал дуудлага	8	5	9	4	80.0
Гал түймрийн тохиолдлын тоо	208	318	240	-78	-24.5
Унтраасан гал түймрийн тоо	146	296	209	- 87	-29.4
Ашигласан ус, тонн	695.3	956.5	387.1	-569.4	-59.5
Ашигласан шатахуун /дизель/, литр	5 004	7 642.0	3 872.5	-3 769.6	-49.3
Ашигласан хөөс, литр	-	2 458	100.0	-2 358.0	-95.9
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	59.5	27.0	13.8	-13.2	-48.9
Аварсан хүний тоо	309	1 060	810	-250	-23.6
Учирсан хохирол, сая.төг	36 791	117 388.2	152 010.0	34 621.8	29.5

¹-дахин их * Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ

ЗУРАГ 16. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 8 сард

ОНЦГОЙ БАЙДАЛ, 2026 оны 8 сард

2026 оны эхний 8 сард 336 аюулт үзэгдэл, ослын дуудлага ирсэнээс худал дуудлага 9 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 дуудлагаар нэмэгдсэн байна.



Дуудлагын тоо
336



Ашигласан шатахуун
3 872.5



Гал түймэр
240



Зарцуулсан мөнгө /сая.төг/
13.8



Аварсан хүний тоо
810



Худал дуудлага
9

Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:

2026 оны 8 дугаар сарын байдлаар 7 төрлийн үйлчилгээг нийт 1740 удаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 41424 сая төгрөгийн хураамж авсан байна.

ХҮСНЭГТ 16. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	2026 VIII сар					
	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)
Нийт	1 740	41424	607	5 811	1 133	35 613
Анхны бүртгэл	220	138	51	88	169	50
Өмчлөх эрх шилжих гэрээ	407	8 140	135	2 700	272	5 440
Барьцааны гэрээ	884	31 945	302	2 369	582	29 576
Бусад гэрээ	6	50	-	-	6	50
Бүртгэлд өөрчлөлт оруулах	146	1 132	79	644	67	488
Урьдчилсан тэмдэглэл	1	5	-	-	1	5
Лавлагаа хуулбар	76	14	40	10	36	4

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: 2026 оны эхний 8 сард 15783 хүнд 25600 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 3508 (18.2%) хүнээр буурсан бол, зарцуулсан зардал 2500 (10.8%) мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 17. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР ЭХНИЙ 8 САРД

Үзүүлэлт	2025 I-VIII			2026 I-VIII		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	377	19 291	23 100	321	15 783	25 600
Халамж үйлчилгээ	35	1 008	2 500	48	316	4 200
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	68	2 178	4 100	13	279	3 000
Анхны тусламжийн сургалт	19	549	960	51	1 047	2 100
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	22	1089	1330	10	818	2 340
Гамшгийн тусламж	2	10	600			
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	52	4 972	4 780	43	4 077	5 030
Донорын өдөрлөг, сурталчилгаа	41	2 131	310	15	1 560	400
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	35	2 171	4 000	39	2 797	4 980
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	103	5 183	4 520	102	4 889	3 550

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2026 оны эхний 8 сард 2814 өргөдөл, гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 18. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, эхний 8 сард

Ангилал	2025 I-VIII	2026 I-VIII	Үүнээс:	
			Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	2 730	2 814	690	2 124
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	26	14	2	12
Нутгийн захиргааны байгууллагууд	1 495	1 475	339	1 136
1800-1200 дугаарын оператор	141	156	44	112
11-11 төвөөс ирсэн	1 033	1 034	262	772
Гар утасны аппликэйшнээр ирсэн		-	-	-
Мессеж		-	-	-
E-Service	26	114	36	78
Facebook		5	-	5
Дижитал сити	5	10	4	6
Хороо бүртгэсэн	4	6	3	3
Smartcar3.0		-	-	-
НМХГ тусгай дугаар		-	-	-

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Иргэдээс 2026 оны эхний 8 сард 2814 өргөдөл, гомдол ирснээс 2124 (75.5%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 690 (24.5%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.



АЖ ҮЙЛДВЭР

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өслөө.

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан 372.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 211.2 (2.3 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхайн олборлолт 209.7 (4.5 дахин) тэрбум төгрөгөөр

өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 5.2 (5.6%) сая төгрөг, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 4.1 (46.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 19. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Нийт үйлдвэрлэлт			2026* VIII
	2024 I-VIII	2025 I-VIII	2026* I-VIII	2025 VIII
	сая төгрөг			Хувь
БҮГД	194 668.5	160 788.5	372 049.9	2.3**
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	51 369.7	60 320.0	270 019.6	4.5**
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	401.2	502.9	721.8	43.5
Металлын хүдэр олборлолт	28 768.8	56 631.7	240 270.7	4.2**
Бусад ашигт малтмал олборлолт	142.2	0.0	0.0	-
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	22 057.5	3 185.4	29 027.1	9.1**
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	136 615.8	92 703.6	97 903.4	5.6
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	8 559.5	28 135.5	10 818.0	- 61.6
Мах боловсруулах, консервлох	4 175.0	23 398.1	142.5	- 99.4
Ундаа үйлдвэрлэл	4 384.5	4 737.3	10 675.6	2.3**
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	101 937.9	40 042.4	59 858.1	49.5
Хувцас үйлдвэрлэл	7 313.8	9 288.9	14 520.4	56.3
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	170.3	173.0	0.0	-
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 541.6	9 751.1	4 494.7	- 53.9
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	3 702.2	2 934.2	3 136.0	6.9
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	2 457.8	1 789.0	4 934.9	2.8**
Тавилга үйлдвэрлэл	1 687.6	64.6	0.0	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	245.1	525.0	141.4	- 73.1
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6 683.0	7 764.8	4 126.8	- 46.9
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	6 683.0	7 764.8	4 126.8	- 46.9


Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 270.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 209.7 (4.5 дахин) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 183.6 (4.2 дахин) тэрбум төгрөгөөр, уул уурхайн туслах үйл ажиллагаа 29.0 (9.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 97.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.2 (5.6%) тэрбум төгрөгөөр буурахад хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 17.3 (61.6%) тэрбум төгрөгөөр, цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5.2 (53.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 (46.9%) тэрбум төгрөгөөр буурахад хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 3.6 (46.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 49.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 54.8 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 43.8 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 1.4 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 17. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний 8 сард



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 349.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 198.0 (2.3 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 210.6 (4.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 9.3 (11.2%)

тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа салбарын борлуулалт 3.2 (41.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Гадаад зах зээлд 2026 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 32.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 32.7 тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрийн салбарын борлуулалт байна.


ХҮСНЭГТ 20.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Нийт борлуулалт			2026* VIII 2025 VIII	Экспорт
	2024 VIII	2025 VIII	2026* VIII		
	сая төгрөг			Хувь	
БҮГД	197 188.6	151 438.4	349 505.1	2.3**	9.4
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	51 563.1	60 520.8	271 135.4	4.5**	0.0
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	537.4	703.8	759.9	8.0	-
Металлын хүдэр олборлолт	28 785.1	56 631.7	240 270.7	4.2**	-
Бусад ашигт малтмал олборлолт	183.1	0.0	1 077.7	-	-
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	22 057.5	3 185.4	29 027.1	9.1**	0.0
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	138 942.5	83 152.7	73 830.2	-11.2	44.3
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	10 567.5	34 910.3	10 653.4	-69.5	1.3
Мах боловсруулах, консервлох	6 179.5	25 271.5	142.5	-99.4	100.0
Ундаа үйлдвэрлэл	4 388.0	9 638.9	10 510.9	9.0	-
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	102 677.6	23 321.8	36 042.1	54.5	88.5
Хувцас үйлдвэрлэл	7 179.6	9 669.0	14 206.6	46.9	4.9
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	242.2	204.8	0.0	0.0	-

Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 541.6	9 751.1	4 494.7	-53.9	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	3 712.5	2 952.7	3 343.1	13.2	-
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	2 169.2	1 753.4	4 934.9	2.8**	-
Тавилга үйлдвэрлэл	1 607.3	64.6	0.0	0.0	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	245.1	525.0	155.5	-70.4	-
УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6 683.0	7 764.8	4 539.5	-41.5	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	6 683.0	7 764.8	4 539.5	-41.5	-

ЗУРАГ 18. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 8 сард





ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 09 дүгээр сарын 15


Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн нийт 799 иргэн байна.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн

иргэдийн тоо 2026 оны эхний 8 сард 799 иргэн бүртгэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 489 (61.2) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 19. ДҮҮРГИЙН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр

Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 44 (5.5%) нь 15-24 насны, 138 (17.3%) нь 25-34 насны, 240 (30.0%) нь 35-44 насны, 220 (29.5%) нь 45-54 насны, 141 (17.6%) 55-аас дээш насны хүмүүс байна.



ЗУРАГ 20. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшинээр эхний 8 сарын байдлаар



БҮЛЭГ

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Э.Анар
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Н.Халиун
III	Гэмт хэрэг	Э.Анар
IV	Төсөв	Э.Анар
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Э.Анар
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа
IX	Аж үйлдвэр	Н.Халиун
X	Хөдөлмөр	Э.Анар

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: Д.МӨНХЗУЛ

Танилцуулга нэгтгэсэн мэргэжилтэн:Б.МИШЭЭЛТ



Авлигатай тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу;

Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/;

22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хахууль овох/;

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар

Факс: (976)-11-311919

Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn

Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,

Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн

тудамж 41 хаягаар

Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг

...НЭГДЭЭ

Үгүй гэж хэлээд өөрчилъё! 110

